



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/76

Мандалговь

“Дундговь аймаг Сайнцагаан сум
3-р цэцэрлэгийн барилгын засварын ажил”-ын
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламжийн “Өвсний үндэс” төслөөс санхүүжих “Дундговь аймаг Сайнцагаан сум 3-р цэцэрлэгийн барилгын засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ж.Гантулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)
Гишүүд: Н.Мэндсайхан (Иргэний төлөөлөл)

Э.Мөнхзол (Иргэний төлөөлөл)
Э.Энхмэнд (Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын барилгын
хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: Б.Адъяасүрэн (Орон нутгийн өмчийн газрын
худалдан авах ажиллагаа хариуцсан
ахлах мэргэжилтэн)

2. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Ж.Гантулга)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай хобогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Адъяасүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ

